



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/143/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа

Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 01. 31 № 11

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2141 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилт 649,021.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт 26,569.9 мянган төгрөг тус тус авсан байна. Хандив тусламжаар 49,293.6 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, аж ахуй, хангамжийн материал үнэ төлбөргүй орлого авчээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 34 арга хэмжээг бүрэн, 7 арга хэмжээг 70.0 хувь, 1 арга хэмжээ 30.0 хувь буюу нийт дүнгээр 91.4 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 90.3 хувиар, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 76.50 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07020049

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Г.ГҮНЖИДМАА

Дансны код	Балансын зүйл	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	180,534.4	143,524.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	755,217.8	699,101.2
	Нийт хөрөнгийн дүн	935,752.2	842,626.2
	Нийт өр төлбөрийн дүн	0.00	393.0
	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	935,752.2	842,233.2
	Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	935,752.2	842,626.2
Орлого үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,552,153.2	756,459.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	744,388.1	849,978.8
	Үйл ажиллагааны үр дүн	807,765.1	(93,519.00)
Цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийсэн үлдэгдэл	911,244.4	935,752.2
	Тайлант оны үр дүн	24,507.9	(93,519.00)
	Эцсийн үлдэгдэл	935,752.3	842,233.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	739,771.4	681,521.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	608,362.5	704,289.9
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	131,408.9	(22,768.1)
	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(32,868.00)	(10,698.0)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	0.00
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	98,540.9	(33,466.1)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	991.8	99,532.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,532.7	66,066.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага цэвэр зээлийн дүн		712,060.8
	Урсгал зардал		701,362.8
	Хөрөнгийн зардал		10,698.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		678,591.6
	Эрүүл мэндийн даатгалын сангаас		649,021.7
	Орон нутгийн төсвөөс		26,569.8
	Урьд оны үлдэгдлээс		99,532.7
	Туслах үйл ажиллагааны орлогоос		3,000.0

Аудитаар 620.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Хуультай холбоотой:** Нийгмийн даатгалын хэлтэст ЭМНДШ 392.9 мянган төгрөгөөр дутуу төлсөн, өглөгөөр бүртгээгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл, 16.1 дэх заалт /Ажил олгогч нь даатгуулагчийн төлбөр зохих нийгмийн даатгалын шимтгэлийг түүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого олох бүртээ энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр тооцон суутгаж, тухайн сард нь багтаан нийгмийндаатгалын санд шилжүүлнэ./-ыг зөрчсөн байна.
- Татварын хэлтэст ХХОАТ 227.7 мянган төгрөгөөр илүү төлсөн, авлагаар бүртгээгүй нь ХХОАТ-ын тухай хуулийн 8.1.1 дахь заалт/цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоо-ыг/ ХХОАТ-ын тухай хуулийн 26.3 дахь заалт / энэ хуулийн 11.1.2-11.1.5-д заасан албан татварыг тухай бүр нь ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх/-уудыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 5,798.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5,798.0 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 5,798.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 3 албан шаардлага өгсөн.

5.2 Албан шаардлага

1. Тендерт шалгараагүй 3 аж ахуйн нэгж байгууллагаас 5,798.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан аж ахуйн нэгжээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Эм боох материалын үлдэгдэлд хугацаа дууссан 1 нэр төрлийн 127 ширхэг 5,221.3 мянган төгрөгийн эм бэлдмэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд таван саяас дээш 88,304.5 мянган төгрөгийн 10 гүйлгээ ил тод байршуулаагүй байна. Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.8-т "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", 6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;"заалттай ницэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бугат сумын Эрүүл мэндийн төв	2	0.6	-	-	2	0.6	2	0.6	-	-	-	-
Дүн	2	0.6	-	-	2	0.6	2	0.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Бугат сумын Эрүүл мэндийн төв	2	5.8	-	-	2	5.8	-	-	-	-	-	-
Дүн	2	5.8	-	-	2	5.8	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бугат сумын Эрүүл мэндийн төв	1						1	
Дүн	-1	-	-	-	-	-	1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтийг	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			